

**“ЖИДАКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 03-р сарын 18-ны өдөр

Дугаар 26/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

“Жидакс” ХК-ийн 2026 оны 03-р сарын 18-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хоёрдугаар тэмдэглэл, компанийн тухай хуулийн 59.4, 62.1.15 дугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. “Жидакс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 22-ны өдөр 13.00 цагт, Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, орхон-1, “Шинэ Монгол Хаад Групп” ХХК-ийн байр, 2-р давхарын хурлын танхимд хуралдуулсугай. Хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Т.Төгс-Од даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04-р сарын 07-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2026 оны 03-р сарын 20-ны өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2026 оны 03-р сарын 23-ны өдөр, 2026 оны 04-р сарын 06-ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 03-р сарын 30-ны өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтуудын жагсаалт, уг бичиг баримтуудтай танилцаж болох газар, хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Долоо. Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2026 оны 04-р сарын 17-ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг тавдугаар хавсралтаар баталсугай.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг даалгасугай.

Зохион байгуулах комиссын дарга: Т.Төгс-Од

Гишүүн: Д.Булгамаа

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилж, даалгах ажлыг зургаадугаар хавсралтаар баталсугай.

Тооллогын комиссын дарга: Г.Сугирсүрэн

Гишүүн: Б.Нямцэцэг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Т.ТӨГС-ОД/